# МОНГОЛ УЛСЫН
# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
# ТУШААЛ

2019 оны 09 сарын 10 өдөр Дугаар А/415 Улаанбаатар хот

Зүрх судасны өвчнөөс сэргийлэх, өвчлөл, нас баралтыг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын “Халдварт бус өвчинтэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Зүрх судасны өвчнөөс сэргийлэх, өвчлөл, нас баралтыг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар батлсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/, Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, мэргэжил арга зүйгээр хангаж, үр дүнг тооцож ажиллахыг Улсын гуравдугаар төв эмнэлэг /Ц.Төмөр-Очир/-т үүрэг болгосугай.
3. Зүрх судасны өвчнөөс сэргийлэх, өвчлөл, нас баралтыг бууруулах арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцож, жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор тус яамны Нийгмийн эрүүл мэндийн газарт тайлагнаж байхыг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
4. Тус тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Я.Амаржаргал/-д даалгасугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

081577

Эрүүл мэндийн сайдын 2019 оны
.09... дүгээр сарын .10...-ны өдрийн
А/415...дугаар тушаалын хавсралт

# ЗҮРХ, СУДАСНЫ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТЫГ БУУРУУЛАХ 2019-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Зорилго | **Зүрх судасны өвчнөөс сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, эмчилгээний цогц тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар зүрх судасны өвчлөл, нас баралтын түвшинг бууруулах** |
|---|---|

Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)

| | Шалгуур үзүүлэлт | Суурь үзүүлэлт | 2019 он | 2020 он |
|---|---|---|---|---|
| | | | | |
| 1. | Зүрх судасны тогтолцооны шалтгаант нас баралт (10000 хүн амд) | 17.8 | 17.6 | 17.5 |
| 2. | Цусны даралт ихсэлт (артерийн дээд даралт ≥140, доод даралт ≥90 ба даралт бууруулах эм хэрэглэж байгаа)-ийн тархалт, хувиар | 27.5 | 25.2 | 24.0 |
| 3. | Цусны даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүн ам, хувиар (40-65 нас) | 65.1 | 69.0 | 73.5 |
| 4. | Хоногт 5 гр-аас их давс хэрэглэж буй хүн ам, хувиар (25-64 нас) | 83.2 | 78.0 | 74.0 |

| № | Үйл ажиллагааны чиглэл | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжүүлэх байгууллага | Хамтрах байгууллага | Хугацаа | Санхүүжилт Эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1. Зүрх судасны өвчнөөс сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, эмчилгээний цогц тусламж, үйлчилгээг сайжруулах, эмчийн хяналтад эрт авч, өвчлөл, нас баралтын тоог бууруулахад чиглэсэн бодлого эрх зүйн орчныг боловсронгуй болгох** | | | | | | | |
| 1.1 | Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт зүрх | 1. Бодлого боловсруулагч нарт зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар ухуулга нөлөөллийн уулзалт, үйл ажиллагааг | Нөлөөллийн үйл ажиллагааны тайлан, Ухуулга нөлөөлөлд оролцогчдын тоо, | НЭМҮТ<br>УГТЭ-ийн Зүрхний төв | Аймаг, нийслэлийн ЭМГ | 2019 | 10 000 000<br>МОН/006 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | судасны өвчний тусламж, үйлчилгээнд тулгамдаж буй асуудлын талаар ухуулга нөлөөллийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах | зохион байгуулах | төрөл | | | | |
| | | 2. Аймаг, нийслэлийн шийдвэр гаргагчдад зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэхэд орон нутгийн оролцоо, дэмжлэгийн талаар нөлөөллийн уулзалт, үйл ажиллагааг зохион байгуулах | Нөлөөллийн үйл ажиллагааны тайлан, Ухуулга нөлөөлөлд оролцогчдын тоо, төрөл | ЭМЯ<br>НЭМҮТ<br>УГТЭ-ийн Зүрхний төв | Аймаг, нийслэлийн ЭМГ | 2019-2020 | 6 000 000<br>МОН/006 |
| | | 3. Зүрх судасны өвчний өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудлын талаар баримтын хуудас, мэдээллийн цомог боловсруулан, түгээх | Ухуулга сурталчилгааны материалын тоо | НЭМҮТ<br>УГТЭ-ийн Зүрхний төв | Төрийн болон төрийн бус байгууллага | 2019-2020 | 5 000 000<br>МОН/006 |
| | | 4. "Хэрх өвчнөөс сэргийлэх" сэдвээр боловсрол, эрүүл мэндийн салбарын удирдах ажилтан, багш нарт ухуулга нөлөөлөл, сургалт явуулж заавар, гарын авлагаар хангах | Ухуулга сурталчилгааны материалын тоо сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо | УГТЭ-ийн Зүрхний төв | ЭМБ-ууд | 2019-2020 | 20 000 000<br>МОН/006 |
| | | 5. Хүүхдийг хэрхийн шалтгаанд зүрхний өвчнөөс сэргийлэх (8/20) | Стрептококкын халдварын хурдавчилсан оношлуураар хангасан байна. | ЭМЯ, ЭМБ | ЭМЯ-ны ЭҮТГ | 2019-2020 | Тухайн байгууллагын төсвийн эх үүсвэр |
| | | 6. Нийтийн биеийн тамир, иог, дасгал хөдөлгөөн, спорт клубээр хичээллэх нөхцөл бололцоог сайжруулах (8/20) | ЭМД-аас санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэсэн шийдвэр | ЭМЯ-ны БТГ, ЭМДЕГ | ЭМЯ-ны холбогдох газар, хэлтэс | 2019-2020 | Эрүүл мэндийн даатгалын сан |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 2. Зүрх судасны өвчний анхдагч болон хоёрдогч урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, эмчилгээний цогц тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 2.1 | Улсын гуравдугаар төв эмнэлгийн Зүрх судасны төвийг бэхжүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх | 1. Улсын гуравдугаар төв эмнэлгийн Зүрхний төвийг тус эмнэлгийн зүрх судасны лавлагаа тусламж үзүүлэх Зүрх судасны үндэсний төв болгон өргөжүүлж, байгуулах | Үйл ажиллагааны тайлан, гарсан шийдвэр | ЭМЯ-ны ЭЗСХО-ын газар УГТЭ, Зүрхний төв | ОУБ, Хөрөнгө оруулагчид Барилгын зураг, төсвийн мэргэжлийн байгууллага | 2019-2020 | Төсөл хөтөлбөр МОН/006 5 000 000 |
| | | 2. Зүрх судасны өвчний оношилгоо, эмчилгээ хийх, судсан дотуурхи катетер лабораторийн тоог нэмэгдүүлэх | Эрүүл мэндийн сайдын тушаал | ЭМЯ-ны БТГ УГТЭ | Харьяалах байгууллага | 2019-2020 | Улсын төсөв |
| | | 3. Зүрх судасны өвчний оношилгоо, эмчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх | Эрүүл мэндийн сайдын тушаал | ЭМЯ-ны ЭҮТГ УГТЭ Зүрхний төв | Харьяалах байгууллага | 2019-2020 | 50 000 000 МОН/006 |
| | | 4. Цусны даралт ихсэх, хүүхдийн стрептококкын халдварын илрүүлэг үзлэгт шаардлагатай эм, урвалж, багаж, хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх (8/20) | Хангагдсан аймгийн тоо | ЭМЯ-ны НЭМГ, ЭҮТГ, ЭЗСХОГ Сангийн яам | ХСҮТ, Аймаг дүүргийн ЗД, аймаг, нийслэлийн ЭМГ, НЭ | 2019-2020 | Тухайн байгууллагын төсвийн эх үүсвэр |
| | | 5. Харвалт, шигдээсийнтасаг, нэгжийг Улсын 1, 2-р төв эмнэлэг, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт шинээр байгуулах (8/20) | Харвалт, шигдээсийн тасаг байгуулагдсан байна. | ЭМЯ-ны ЭҮТГ, ЭЗСХОГ БХЯ | улсын 1, 2-р төв эмнэлэг, ТТАХНЭ, | 2019 | Улсын төсөв |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | ЗСӨ-ний урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ, хяналтын олон улсын жишигт нийцсэн хөтөлбөр, зааврыг хэрэгжүүлэх | 1. Зүрх судасны өвчний нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц, оношилгоо, эмчилгээний заавар, гарын авлагыг орчуулан, хэвлүүлж түгээх | Эрүүл мэндийн сайдын тушаал, Шинээр боловсруулж, хэвлүүлсэн хэрэгжүүлж байгаа багц, гарын авлага, журам, зааврын тоо | ЭМЯ-ны НЭМГ ЭҮТГ, УГТЭ Зүрхний төв | АШУҮИС Европын зүрхний нийгэмлэг Монголын зүрхний нийгэмлэг | 2019-2020 | 5 000 000 MOH/006 |
| | | 2. Зүрх судасны нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд сонгогдсон ЭМБ-д хурдавчилсан үнэлгээ хийж, зөвлөмж гаргах | Үнэлгээний тайлан | ЭМЯ-ны НЭМГ, ЭТГ | ОУБ, ТББ, ЭМБ-ууд | 2019 | ДЭМБ |
| | | 3. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд үзүүлэх зүрх судасны нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц болон түүнийг хэрэгжүүлэх зааврыг орчуулж, хэвлүүлэх | Орчуулсан заавар, хэвлүүлсэн тоо | ЭМЯ-ны НЭМГ | НЭМҮТ, ОУБ, ТББ, | 2019 | ДЭМБ |
| | | 4. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд үзүүлэх зүрх судасны нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг хэрэгжүүлэх талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд үе шаттайгаар сургалт зохион | Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо | ЭМЯ-ны НЭМГ, ЭТГ | УГТЭ, ДЭМБ | 2019-2020 | ДЭМБ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах | | | | | |
| | | 5. Зүрхний хавхлагийн гажгийн оношилгоо, эмчилгээ хяналтын талаар удирдамж боловсруулж хэрэгжүүлэх | Батлагдсан удирдамж, хэрэгжилт | УГТЭ, Зүрхний төв, ЗСТ ЗМЗТ | ЭМХТ Аймаг, нийслэлийн ЭМГ | 2019-2020 | 2 000 000 МОН/006 |
| | | 6. Стрептококкын халдварыг хур-давчилсан аргаар оношлох орчин үеийн аргыг холбогдох эмнэлзүйн стандарт, заавәрт оруулах (8/20) | Стандарт,заавәрт тусгагдсан байдал | УГТЭ, Зүрхний төв, ЗСТасаг | ЭМЯ-ны ЭҮТГ, ЭТГ ЭХЭМҮТ | 2019 | 1 000 000 МОН/006 |
| | | 7. Хүүхдийн хэрхийн шалтгаант зүрхний эмгэгийг эрт илрүүлэх үзлэг шинжилгээ хийх, оношийг бүрэн баталгаажуулах эмчлэх (8/20) | Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо, онош баталгаажсан, эмчлэгдсэн хүүхдийн тоо | Аймаг, дүүргийн НЭ | УГТЭ-ийн Зүрх судасны төв<br><br>ЭХЭМҮТ | 2019-2020 | Тухайн байгууллагын төсвийн эх үүсвэрээс |
| 2.3 | Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, хянах ажлыг эрхэлдэг эмч, эрүүл мэндийн мэргэжилтэнг сургалтанд хамруулах замаар мэдлэг, мэргэжлийг | 1. Зүрх судасны эмч нарын мэдлэг, мэргэшил, ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулах | Зохион байгуулсан сургалтын тайлан, үр дүн, сургалт, уулзалт, зөвлөгөөний тоо, оролцогчдын тоо | УГТЭ, Зүрхний төв | ЭМЯ-ны ТЗУГ, ЭМХТ Аймаг, нийслэлийн ЭМГ МЗСЭНН | 2019-2020 | 80 000 000 МОН/006 |
| | | 2. Зүрх судасны өвчний тусламж, үйлчилгээний талаар үндэсний болон ОУ-ын хурал, зөвлөгөөн, уулзалт семинар зохион байгуулах, оролцох | Зохион байгуулсан сургалтын тайлан, үр дүн, сургалт, уулзалт, зөвлөгөөний тоо, оролцогчдын тоо | ЭМЯ, УГТЭ, Зүрхний төв | НЭМҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ, Харьяалах байгууллгууд | 2019-2020 | 100 000 000<br><br>МОН/006 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дээшлүүлэх | 3. Өрх, сум, тосгоны ЭМТ, аймаг, дүүргийн НЭ-ийн эмч, мэргэжилтүүдэд эмнэлзүйн зааврыг мөрдүүлэх, хяналт тавих сургалт явуулах (8/20) | Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо, үйл ажиллагааны тайлан | ЭМЯ-ны ЭТГ, ЭМХТ, УГТЭ, Зүрхний төв | Харьяалах байгууллага | 2019-2020 | 12 000 000 МОН/006 |
| | | 4. Судсан дотуурхи оношилгоо эмчилгээний ажлын байран дээрх сургалтыг ОУ-ын багийн тусламжтай зохион байгуулах | Мэс ажилбар хийгдсэн тоо, | ЭМЯ-ны ЭТГ УГТЭ Зүрхний төв | Харьяалах байгууллага ОУБ | 2019-2020 | 30 000 000 МОН/006 |
| | | 5. Зүрх судасны эмч нарын цахим програм ашиглалтыг сайжруулах тасралтгүй сургалт зохион байгуулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | ЭМЯ-ны ЭМЦМХ УГТЭ Зүрхний төв | Харьяалах байгууллага | 2019-2020 | 10 000 000 МОН/006 |
| | | 6. Зүрх судасны мэс заслын чадавхийг нэмэгдүүлэх ажлын байран дээрх сургалт-мэс заслыг ОУ-ын мэргэжилтнүүдтэй хамтран мэргэшүүлэх сургалт зохион байгуулах | Мэс засал хийлгэж эдгэсэн иргэдийн тоо, гадаадын багийн ирэлтийн тоо | ЭМЯ-ны ЭТГ УГТЭ Зүрхний төв | Харьяалах байгууллага, ОУБ | 2019-2020 | 280 000 000 МО Н/006 |
| | | 7. Зүрхний мэс заслын эмч, сувилагч нарыг багаар нь мэргэжил дээшлүүлэх гадаад улсад сургалтад хамруулах | Сургалтын тоо/ хугацаа | ЭМЯ-ны ТЗУГ ЭМХТ УГТЭ Зүрхний төв | Харьяалах байгууллага, ОУБ | 2019-2020 | 100 000 000 МОН/006 |
| | | 8. Дотрын эмч нарт ревматологийн сургалтыг зохион байгуулах | Хамрагдсан эмчийн тоо | ЭМЯ-ны ТЗУГ ЭМХТ АШУҮИС | ЭМХТ, аймаг, нийслэлийн ЭМГ | 2018-2020 | Улсын төсөв |
| | | 9. Артерийн гипертензийг илрүүлэх, оношлох, эмчлэх, анхдагч болон хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн | Сургалт, хамрагдсан эмч нарын тоо, | УГТЭ, НЭМҮТ, АШУҮИС | ЭМХТ, аймаг, нийслэлийн ЭМГ | 2019-2020 | Улсын төсөв |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | чиглэлээр аймаг, дүүргийн эмч нарт сургалт явуулж, зааврын мөрдөлтөд хяналт тавих | | | Хаан банк сан | | |
| 2.4<br>Зүрх судасны өвчний эрсдлээс сэргийлэх үйл ажиллагааг өргөжүүлэх | 1. Зүрх судасны өвчний эрсдлийг 10 жилийн өмнөөс тооцох, сэргийлэх аргачлал боловсруулах, нэвтрүүлэх | Эрүүл мэндийн сайдын тушаал | ЭМЯ-ны НЭМГ УГТЭ, НЭМҮТ | Аймаг, нийслэлийн ЭМГ, ОУБ | 2019-2020 | 3 000 000 МОН/006 |
| | 2. Аймаг, нийслэлийн хүн амын Зүрх судасны эрсдэлт хүчин зүйлсийн үнэлгээг орон нутгийн ЭМБ-тай хамтран хийж, тухайн орон нутгийн хүн амд чиглэсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлийг зорилтот бүлэг бүрээр тодорхойлох | Эрсдэлийн үнэлгээний дүн | ЭМЯ, УГТЭ, НЭМҮТ | Аймаг, нийслэлийн ЭМГ | 2019-2020 | Улсын төсөв |
| | 3. Артерийн гипертензийн эсрэг үндэсний аяныг өргөжүүлэх | Аяны хөтөлбөр хэрэгжилт | УГТЭ, ХААН Банк Сан | Аймаг, нийслэлийн ЭМГ, ХААН Банкны салбарууд | 2019-2020 | ЭМДС |
| | 4. Зүрх судасны өвчлөл өндөртэй аймгуудыг сонгон Артерийн гипертенз болон бусад Зүрх судасны өвчний илрүүлэг үзлэг, эрсдэлийн үнэлгээ, эрүүл мэндийн боловсролын кампанит ажил зэрэг зорилтот үйл ажиллагааг хэрэгжүүлэх | Илрүүлэг үзлэгийн too Сургалтын тоо хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн, иргэдийн тоо | УГТЭ, Зүрхний төв, ЗСТ, ХТ, НЭМҮТ | Аймаг, нийслэлийн ЭМГ ХААН Банк САН | 2019-2020 | Улсын төсөв |
| | 5. ӨЭМТ, СЭМТ, аймаг, дүүргийн хүн амын дунд артерийн даралт ихсэлтийн | Эрт илрүүлгийг нэмэгдүүлэх хүрээнд зохион | Өрх, сум, тосгоны ЭМТ | Аймаг, нийслэлийн ЭМГ, | 2019-2020 | Улсын төсөв (ӨСТЭМТ) |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | эрсдлийн үнэлгээ хийж, үр дүнд суурилсан үйл ажиллагааг хувь хүн, гэр бүл, байгууллага, хамт олны оролцоотой зохион байгуулах | байгуулсан арга хэмжээний үр дүн, тайлан | | төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллага | | |
| | | 6. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын зүрх судасны өвчний диспансерын хяналтыг нэмэгдүүлэх | Жилд 5-аас доошгүй аймаг, Нийслэлийн 10-аас доошгүй өрхийн эрүүл мэндийн төвийг хамруулна. | УГТЭ<br>НЭМҮТ<br>ЭМБ-ууд | Аймаг, нийслэлийн ЭМГ | 2019-2020 | Улсын төсөв (ӨСТЭМТ) |
| | | 7. “Давсгүй цай” аяныг зорилтот аймгуудад зохион байгуулах, дүгнэх | Аяны хөтөлбөр хэрэгжилт | НЭМҮТ, УГТЭ ХААН Банк Сан, Зүрхний төв ЗСТ,ХТ | Аймаг, нийслэлийн ЭМГ, ХААН Банкны салбарууд | 2019-2020 | ЭМДС |
| | | 8. Зүрхний шигдээс, харвалтын үед үзүүлэх яаралтай тусламжийн талаар хүн амын мэдлэг, чадварыг сайжруулах (8/20) | МСС-ны хөтөлбөр, удирдамж, Хамрагдсан хүний тоо | УГТЭ<br>Зүрхний төв<br>НЭМҮТ | ЭМБ-ууд | 2019-2020 | ДЭМБ<br>ЭМДС |
| **Зорилт 3. Хүн амын эрүүл аж төрөх мэдлэг, хандлага, дадлыг сайжруулах, байгууллага, аж ахуйн нэгжид эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх, ЗСӨ-нд нөлөөлж байгаа анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах** | | | | | | | |
| 3.1 | Зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлс /архи, тамхи, хөдөлгөөний хомсдол, жингийн илүүдэл, стресс/ урьдчилан сэргийлэх чиглэлээр зорилтот бүлэгт | 1. Цусны даралт, цусан дахь өөх тос, глюкоз, биеийн жинг иргэн өөрөө хянах аргачлал боловсруулах<br>2. Архи, тамхи, хөдөлгөөний хомсдол, жингийн илүүдэл, стресс гэх мэт сэдвээр МСС-ны материал боловсруулах, | • Боловсруулсан мэдээлэл сурталчилгааны материалын тоо<br>• Хэвлүүлсэн болон түгээсэн материалын тоо | НЭМҮТ<br>УГТЭ<br>Зүрхний төв | Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЭМБ<br>ТББ<br>ОУБ | 2019-2020 | ДЭМБ<br>ЭМДС |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зориулсан МСС-ны материал, контент боловсруулах, хэвлүүлэх, түгээх | хэвлүүлэх, түгээх<br>3. Аргачлал болон боловсруулсан мэдээлэл, сурталчилгааны материалыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэх | | | | | |
| 3.2 | Хүн амын дунд амьдралын буруу хэвшил, эрсдэлт зан үйлийг өөрчлөх чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа зохион байгуулах | 1. Эрүүл орчин, зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, архи, тамхинаас татгалзах чиглэлээр ЭМАШБ-д хүн амд суурилсан эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах | Зохион байгуулсан сургалтын тоо<br>Сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн тоо | Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЭМБ ТББ ОУБ | НЭМҮТ УГТЭ ЗСТ | 2019-2020 | ДЭМБ ЭМДС |
| 3.3 | Цахим хуудас, нийгмийн сүлжээгээр Зүрх судасны өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, биеийн жингээ хянах, дасгал хөдөлгөөнийг хэвшүүлэх, архиний хэрэглээг багасгах, давсны хэмжээг хязгаарлах, жимс, хүнсний ногоо ихээр | 1. Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны инфографик, видео, шторк боловсруулах<br>2. ЭМБ-дын цахим хуудас, нийгмийн сүлжээгээр хуваарийн дагуу мэдээлэл түгээх<br>3. Хүн амын зан үйлийн буруу хэвшил, зан үйлийг өөрчлөх, эрсдэлт хүчин зүйлс, урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагатай тогтмол, урт хугацаанд гэрээ байгуулан | Батлагдсан хуваарь<br>Байршуулсан МСС-ны материалын тоо<br>Хандалтын тоо | НЭМҮТ УГТЭ | Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЭМБ ТББ ОУБ | 2019-2020 | 65 000 000 МОН/006 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэглэх, тослог багатай сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааг түгээх хуваарь батлуулах, хэрэгжүүлэх | ажиллах | | | | | |
| 3.4 | Зүрх судасны өвчнөөс сэргийлэх чиглэлээр ЕБС-ийн сурагчдад зориулсан үйл ажиллагааг өргөжүүлэх | 1. ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн багш, нийгмийн ажилтан, эмч нарт Зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлс, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг үзлэгийн талаар сургалт зохион байгуулах | Үйл ажиллагааны тайлан | ЭМЯ<br>БСШУСЯ<br>НЭМҮТ<br>УГТЭ | Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЭМБ, Боловсролын байгууллага<br>ТББ<br>ОУБ | 2019-2020 | 20 000 000 МОН/006 |
| | | 2. ЕБС-ийн албан болон албан бус боловсролын хөтөлбөрт ЗСӨ-ний талаарх агуулгыг нэмэгдүүлэх ухуулга нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах | | | | | |
| | | 3. Хүүхдийг хэрэхийн шалтгаант зүрхний өвчнөөс сэргийлэх зорилгоор Аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай хийх үр дүнгийн гэрээнд сурагчдыг хяналтанд авч эрүүлжүүлэх арга хэмжээг тусган хэрэгжүүлэх (8/20) | Тусгасан Засаг даргын гэрээ | ЭМЯ-ны БТГ, ТЗУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга | 2019-2020 | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 4. Сургуульд суурилсан сурагчдын эрүүл мэндийн 3 дахь судалгаанд гүйлсэн булчирхайн архаг үрэвсэл, хэрх өвчний тархалтын түвшинг тодорхойлох талаар асуумж оруулж судлах (8/20) | хэрх өвчний тархалтын түвшинг тодорхойлох талаар асуумжийг тусгасан байна. Тайлан | НЭМҮТ | АШУҮИС | 2019-2020 | - |
| 3.5 | Ямар ч хэлбэрийн тамхидалтад үл өртөх, тамхичдыг илрүүлэх, тамхичдын тоог бууруулах, дам тамхидалтад өртөхгүй байх чиглэлээр хийх үйл ажиллагааг өргөжүүлэх | 1. Тамхинаас гаргах, тамхинаас гарч буй хүмүүсийг дэмжих үйлчилгээг утсаар болон интернетээр өгөх үйлчилгээг нэвтрүүлэх | Утсаар болон интернетээр зөвлөгөө авсан хүмүүсийн тоо, хандалт, тайлан | НЭМҮТ | Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЭМБ ТББ ОУБ | 2019-2020 | ДЭМБ, ЭМДС |
| | | 2. Тамхидалтыг бууруулах, дам тамхидалтад өртөхөөс сэргийлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн болон эрүүл мэндийн боловсролын кампанит аян зохион байгуулах | Сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны тайлан | НЭМҮТ УГТЭ ЗСТ | Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЭМБ ТББ ОУБ | 2019-2020 | ДЭМБ, ЭМДС |
| | | 3. Тамхигүй аймаг, дүүрэг, сум, баг, байгууллага, сургууль болох хөдөлгөөнийг эрчимжүүлэх | Үйл ажиллагааны тайлан | НЭМҮТ | Аймаг, нийслэлийн ЗДТГ | 2019-2020 | ДЭМБ, ЭМДС |
| 3.6 | "Цусны даралтаа хянаж хэвшье" хөдөлгөөнийг гэр бүл, хамт олон, байгууллагын хүрээнд идэвхижүүлэх | 1. Цусны даралт зөв хэмжих, түүнийг хянах аргачлал, зөвлөмж боловсруулж, хэвлүүлэх, түгээх<br>2. Цусны даралтаа зөв хэмжих, хянах чиглэлээр олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр сурталчлах, | Үйл ажиллагааны тайлан | УГТЭ, НЭМҮТ, ЭҮТГ Бүх шатны ЭМБ-ууд | Хэвлэл мэдээллийн байгуулага, Төрийн болон ТББ Аж ахуйн нэгж байгууллага ОУБ | 2019-2020 | ДЭМБ, ЭМДС |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3. Олон нийтийн газар, зах, дэлгүүр, хоолны газар, эмийн сан, аж ахуйн нэгж, үйлдвэр, албан байгууллагууд цусны даралт хэмжигч аппараттай байх хөдөлгөөн өрнүүлэх<br>4. Бүх эмийн сангууд цусны даралт хэмжигчтэй байх талаар стандартад тусгах | | | | | |
| 3.7 | Байгууллага, аж ахуйн нэгжид эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэх | 1. Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, сургууль<br>• Эрүүл ажлын байр<br>• Эрүүл хоолоор үйлчилдэг байгууллага<br>• Ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж хэвшүүлсэн байгууллага<br>• 10000 алхам<br>• Ажилтан албан хаагчдаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, үзлэг оношилгоонд хамруулж хэвшсэн байгууллага<br>• Тамхигүй ажлын байр | ЭМД Байгууллага<br>Эрүүл ажлын байрны тоо<br>Эрүүл хоолоор үйлчилдэг ажлын байр, нийтийн хоолны газрын тоо<br>Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ажиллагчдын тоо | ЭМЯ<br>НЭМҮТ<br>Аймаг, нийслэлийн ЗДТГ | Аймаг, нийслэлийн ЭМГ<br>Аж ахуйн нэгж байгууллага<br>Төрийн байгууллага | 2019-2020 | ЭМДС |
| 3.8 | Зүрх судасны өвчний завсрын эрсдэлт хүчин зүйлсийн илрүүлэг, хяналтыг эрчимжүүлэх мэдээлэл сургалт сурталчилгаа | 1. Зүрх судасны өвчний завсрын эрсдэлт хүчин зүйлсийн талаар эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа<br>2. Зүрх судасны өвчний завсрын эрсдэлт хүчин зүйлсийн эрт илрүүлэг үзлэгт эрсдэлт бүлгийн хүн амыг хамруулах | Үйл ажиллагааны тайлан | УГТЭ<br>ЗСТ | Аймаг, нийслэлийн ЭМГ | 2019-2020 | 10 000 000 МОН/006 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд эрчимжүүлэх | | | | | |
| **Зорилт 4. Зүрх судасны өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлж, ЗСӨ-ий бүртгэл, мэдээлэл, тандалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим, нээлттэй тогтолцоог орон нутаг, бусад салбар, үндэсний хэмжээнд бий болгож бэхжүүлэх** | | | | | | | |
| 4.1 | Зүрхний архаг өвчний (I50) талаарх үндэсний хэмжээний суурь судалгааны сан, эмнэл зүйн нотолгоо бий болгох | 1. Монгол хүн амын дунд зүрхний дутагдлын тархвар зүйг судлах судалгаа хийх | Эрх бүхий байгууллагын шийдвэр, тушаал | ЭМЯ-ны ЭҮТГ УГТЭ | БСШУСЯ, ШУТС | 2019-2020 | 5 000 000 ШУТС |
| | | 2. Зүрхний дутагдлын оношилгоо, эмчилгээний эдийн засгийн өртөг үр дүнгийн болон эмнэл зүйн үр дүнгийн судалгаа хийх | Судалгааны дүн | ЭМЯ-ны ЭҮТГ УГТЭ, Зүрхний төв, ЗСТ, АШУҮИС | БСШУЯ, ШУТС | 2019-2020 | 5 000 000 ШУТС |
| | | 3. Монгол хүн амын дунд зүрхний дутагдлын, түүний хүндрэлд хүргэж буй шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийг нарийвчлан гаргах | Судалгааны тайлан, үр дүн | ЭМЯ УГТЭ | БСШУСЯ, ШУТС | 2019-2020 | 5 000 000 ШУТС |
| | | 4. Зүрхний дутагдлын илрүүлэг, оношилгоо, тавиланг тодорхойлох оношилгоонд зарим биомаркер (BNP, NT-pro BNP, тропонин TI гм) болон багажын шинжилгээ оношилгооны үр дүн, ач холбогдлыг судлах | Судалгааны тайлан, үр дүн | ЭМЯ-ны ЭҮТГ УГТЭ | БСШУСЯ, ШУТС | 2019 | 5 000 000 ШУТС |
| | | 5. Зүрх судасны өвчин ба давсны хэрэглээний эмнэлзүйн судалгааг хийх | Судалгааны тайлан | ЭМЯ-ны ЭҮТГ, УГТЭ | НЭМҮТ, БСШУСЯ, ШУТС | 2019-2020 | ОУБ, ЭМДС, ШУТС |
| 4.2 | Хүн ам болон эмнэлэгт | 1. Зүрх судасны өвчний тандалтын болон эмч, | Бүртгэл, хяналт, тандалтын | ЭМЯ-ны ЭМЦМХ | Харьяалах байгууллага | 2019-2020 | 2 000 000 МОН/006 |